



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө шилжүүлэн бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсвийн хөрөнгөөр худалдан авсан сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 591,800,000.00 (таван зуун ерэн нэгэн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газар, түүний харьяа газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга У.Баярбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрь
2019 оны 07 дугаар сарын 11-ны өдрийн
331 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Нэгжийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1.Орон сууц					
1	Орон сууц	2014	39,000,000.00	37 м2	39,000,000.00
	Дүн				39,000,000.00
2.Авто тээврийн хэрэгсэл					
1	Ланд круйзер-200	2017	149,000,000.00	1	149,000,000.00
2	Тоёото приус 20	2017	12,500,000.00	1	12,500,000.00
3	Хьюндай старекс	2017	69,500,000.00	1	69,500,000.00
4	Тоёото приус-20	2017	12,500,000.00	1	12,500,000.00
5	Тоёото приус-20	2017	12,500,000.00	1	12,500,000.00
6	Тоёото приус-20	2017	12,500,000.00	1	12,500,000.00
7	Тоёото Приус 20	2017	12,500,000.00	1	12,500,000.00
8	Дайхацу хайжит	2017	7,000,000.00	1	7,000,000.00
9	УАЗ Фургон	2018	32,000,000.00	1	32,000,000.00
10	УАЗ хантер	2018	34,800,000.00	1	34,800,000.00
11	Ландкруйзер-200	2018	198,000,000.00	1	198,000,000.00
	Дүн			11	552,800,000.00
Нийт дүн				12	591,800,000.00
					(таван зуун ерэн нэгэн сая найман зуун мянган)